Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн
байнгын хорооны 2020 оны .... дугаар
тогтоолын хоёрдугаар хавсралт

## НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН АНКЕТ

| Д/д | Шалгуур үзүүлэлт | Мэдээлэл |
|---|---|---|
| 1 | **Нэр**<br>Овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, нэрээ өөрчилж байсан бол өмнө нь хэрэглэж байсан нэр | Овог: **ГЭРСЭНЗ**<br>Эцгийн нэр: **ГАНХУЯГ**<br>Өөрийн нэр: **АГАР-ЭРДЭНЭ** |
| 2 | **Хүсэлт гаргагчийн хаяг**<br>Иргэний үнэмлэхэд байгаа хаяг | |
| 3 | **Төрсөн огноо**<br>Төрсөн газар | |
| 4 | **Боловсрол**<br>Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн жагсаан бичнэ. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ. | Суралцсан сургууль: **НЬЮ САУТ УЭЛЬСИЙН ИХ СУРГУУЛЬ, ХУУЛИЙН СУРГУУЛЬ (LAW SCHOOL, UNIVERSITY OF NEW SOUTH WALES, AUSTRALIA)**<br>Суралцсан хугацаа: 2016/12 сар – 2018/01 сар<br>Авсан зэрэг: Хүний эрхийн эрх зүй ба бодлогын магистр (Master of Human Rights Law and Policy)<br>Огноо: 2018/01/24<br><br>Суралцсан сургууль: **МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ, ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ**<br>Суралцсан хугацаа: 2006/10 сар – 2008/06 сар<br>Авсан зэрэг: Хууль зүйн магистр (LL.M)<br>Огноо: 2008/06/26<br><br>Суралцсан сургууль**: МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ, ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ**<br>Суралцсан хугацаа: 2001/09 сар – 2006/06 сар<br>Авсан зэрэг: Хууль зүйн бакалавр (LL.B)<br>Огноо: 2006/06/19 |
| 5 | **Ажил эрхлэлт**<br>Их, дээд сургууль төгссөнөөс хойш ажилласан төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон бусад байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсаан | Ажил олгогчийн нэр: **МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС**<br>Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Тусгаар тогтнолын талбай, Засгийн газрын 11-р байр |

| | | |
|---|---|---|
| | бичнэ. Ажил олгогчийн нэр, хаяг, утас, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ. | Утас: 262902<br>Цахим хуудас: www.nhrcm.gov.mn<br>Ажлын байрны нэр: Бодлогын дүн шинжилгээ хариуцсан референт, Гомдол, хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, Хүний эрхийн боловсрол, судалгааны хэлтсийн дарга<br><br>Ажил олгогчийн нэр: **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ**<br>Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Зайсангийн гудамж, Үндсэн хуулийн цэцийн ордон<br>Утас: 260011<br>Цахим хуудас: www.conscourt.gov.mn<br>Ажлын байрны нэр: Шинжээч, хуралдааны нарийн бичгийн дарга<br><br>Ажил олгогчийн нэр: **ИНВЕКС ХХК**<br>Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Инвекс ХХК-ийн байр<br>Утас: 75754343<br>Цахим хуудас: www.invex.mn (тухайн үеийн)<br>Ажлын байрны нэр: Хуулийн хэлтэст хуулийн мэргэжилтэн<br><br>Ажил олгогчийн нэр: **АНОД БАНК**<br>Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Залуучуудын өргөн чөлөө-21 (тухайн үеийн)<br>Утас: 464114 (тухайн үеийн)<br>Цахим хуудас: www.anodbank.com (тухайн үеийн)<br>Ажлын байрны нэр: Төслийн удирдлагын газарт хуулийн мэргэжилтэн, Байгууллагын банкны газарт хуульч |
| **6** | **Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал**<br>Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн эсхүл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний алинд нэр дэвшиж байгаа талаар бичнэ. | Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн |
| **7** | **Эрх зүйч мэргэжлээр эрхэлсэн ажил**<br>Хүсэлт гаргагч эрх зүйч мэргэжлээр сүүлийн арваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.<br>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;<br>-ажлын байрны тодорхойлолт;<br>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих | <br>**Албан тушаалын нэр:** Хүний эрхийн боловсрол, судалгааны хэлтсийн дарга (2013-2016 онд Бодлого, дүн шинжилгээ, хүний эрхийн боловсролын хэлтэс нэртэй байсан.)<br>**Ажилласан хугацаа:** 2013-2016, 2018 оноос одоог хүртэл<br>**Ажлын байрны тодорхойлолт:** Хүний эрхийн боловсролыг дэмжих, түгээх, хууль тогтоомж, захиргааны байгууллагын шийдвэрийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал гаргах, хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбогдсон хууль |

| | | |
|---|---|---|
| | мэдээлэл;<br>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл. | тогтоомжийг боловсронгуй болгох тухай санал уламжлах чиг үүргийн хүрээнд нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг Тамгын газрын даргын өмнө хариуцах.<br><br>**Албан тушаалын нэр:** Гомдол, хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга<br>**Ажлын газрын хаяг:** Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, ЗГ-ын 11-р байр<br>**Ажилласан хугацаа:** 2012-2013<br>**Ажлын байрны тодорхойлолт:** Комиссын гишүүдийг гомдол, мэдээлэл хянан шийдвэрлэх, хяналт шалгалт хийх хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийн хүрээнд нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, гүйцэтгэлийн үр дүнг Ажлын албаны даргын өмнө хариуцах.<br>**Албан тушаалын нэр:** Бодлогын дүн шинжилгээ хариуцсан референт<br>**Ажлын газрын хаяг:** Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, ЗГ-ын 11-р байр<br>**Ажилласан хугацаа:** 2012/01-2012/09<br>**Ажлын байрны тодорхойлолт:** Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн төсөл боловсруулах, хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн төсөл хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийж, Комиссын гишүүний саналын төсөл боловсруулах, хүний эрхийн асуудлаарх судалгааны ажлыг төлөвлөх, зохион байгуулах ажлыг Хэлтсийн даргын өмнө хариуцах.<br>**Албан тушаалын нэр:** Шинжээч, хуралдааны нарийн бичгийн дарга<br>**Ажлын газрын хаяг:** Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Зайсангийн гудамж, Үндсэн хуулийн цэцийн ордон<br>**Ажилласан хугацаа:** 2009/06-2012/01<br>**Ажлын байрны тодорхойлолт:** Шинжээчээр Үндсэн хуулийн цэцийн гишүүдэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, Үндсэн хуульд заасан нэр бүхий субьектээс ирүүлсэн хүсэлтэд Үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд дүн шинжилгээ хийж, Цэцийн гишүүний маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх асуудлаарх шийдвэрийн төсөл боловсруулах; Цэцийн хуралдааны нарийн бичгийн даргаар Цэцийн хуралдааны товыг гаргах, бага, дунд, их суудлын хуралдааны бэлтгэлийг хангах, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх болон маргаан эцэслэн шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцож тэмдэглэл хөтлөх, зөвлөлдөх тасалгааны протокол хөтлөх, Цэцийн шийдвэрийг албажуулах, нийтэд мэдээлэх.<br>**Ажлын байрны тодорхойлолт:** Байгууллагын банкны газарт зээлийн хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгжийн хүсэлтэд Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл |

| | | |
|---|---|---|
| | | ажиллагааны тухай хууль, Иргэний хуульд заасны дагуу хууль зүйн дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргах, зээлийн баталгаа, батлан даалт, аккредитив гаргах ажлыг хариуцан гүйцэтгэж, үйл ажиллагааны үр дүнг Байгууллагын банкны газрын захирлын өмнө хариуцах. |
| 8 | **Ёс зүй**<br>Доор дурсан асуудлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалллаар бичиж, түүний гол агуулгыг тодорхойлно.<br>-сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байсан эсэх;<br>-сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан эсэх. | Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байгаагүй.<br><br>Сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй. |
| 9 | **Хууль зүйн өндөр мэдлэг, чадвар**<br>Хүсэлт гаргагчийг хууль зүйн өндөр мэдлэг, чадвартай гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.<br>-үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;<br>-үйл ажиллагааны гол агуулга;<br>-үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;<br>-үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;<br>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл;<br>-хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. | **ҮЙЛ АЖИЛЛАГАА №1**<br>Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; **Монголын хуульчдын холбооны үргэлжилсэн сургалт, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүгч нарт зохион байгуулсан сургалт, Улсын ерөнхий прокурорын газраас прокуроруудад зохион байгуулсан сургалт, Монголын өмгөөлөгчдийн холбооноос өмгөөлөгчдөд зохион байгуулсан сургалтуудад “Хүний эрхийн олон улсын гэрээг хууль, шүүхийн практикт хэрэглэх нь” сэдвээр бие даан сургалт хийсэн**. **(2019/12/21 Монголын өмгөөлөгчдийн холбоо, 2019/11/04 Улсын ерөнхий прокурорын газар, 2019/10/21 Монголын хуульчдын холбоо, 2019/10/04 Монголын өмгөөлөгчдийн холбоо, 2019/03/27 Монголын хуульчдын холбоо, 2019/03/18 Шүүхийн ерөнхий зөвлөл)**<br>Үйл ажиллагааны гол агуулга; Хүний эрхийн олон улсын гэрээ нь Монгол Улсын хууль тогтоомжийн нэг хэсэг бөгөөд эдгээр гэрээний хэрэглээг хуулийн практикт нэмэгдүүлснээр зөрчигдсөн эрхийг сэргээх, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд дэвшил гарна гэж үздэг. Энэ сэдвээр хүний эрхийн олон улсын гэрээний үндэсний эрх зүйн тогтолцоонд эзлэх байр суурь, эрх зүйн монист болон дуалист хандлагын хэрэглээ, эрүү, иргэн, захиргааны хэрэг, маргааныг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд нэгдэн орсон хүний эрхийн олон улсын суурь 8 гэрээ, түүний Нэмэлт Протоколуудыг хэрэглэх асуудал, НҮБ-ын гомдлын механизмд хувь хүн гомдлоо шийдвэрлүүлэх процесс, хүний эрхийн олон улсын гэрээг шүүхээс тайлбарлах зэрэг асуудлыг багтаасан багц сургалтын агуулгыг боловсруулж сургалтыг бие даан хийсэн.<br>Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Дагнасан энэ сэдвээр 2019 онд 6 удаагийн сургалтыг 250 гаруй хуульч, шүүгч, прокуроруудад хийсэн. Мөн 2018 онд дээрх сургалтыг зохион байгуулсан.<br>Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, Улсын ерөнхий прокурорын газрын Сургалтын төв, Монголын хуульчдын |

| | | |
|---|---|---|
| | | холбооны Сургалтын хороо, Монголын өмгөөлөгчдийн холбоо Сургалтын хөтөлбөрийн заримыг хавсаргав.<br><br>**ҮЙЛ АЖИЛЛАГАА №2**<br>Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; **Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажил (ХЭҮК, ХЗДХЯ, 2013-2019 он)**<br>Үйл ажиллагааны гол агуулга; ХЭҮК-ын тухай хуулийг НҮБ-аас баталсан “Парисын зарчмууд” баримт бичиг, хүний эрхийн үндэсний байгууллагуудыг Магадлан итгэмжлэх дэд хорооны зөвлөмжид нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байсан бөгөөд ялангуяа Комиссын бие даасан байдал, санхүү, хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх, гомдол шалгаж шийдвэрлэх эрх хэмжээг өргөтгөх, Комиссын гишүүдийн томилгоог ил тод, нээлттэй сонгон шалгаруулалтын зарчмаар явуулах зэрэг зөвлөмжид нийцүүлэх зорилгоор 2013 оноос ХЭҮК ажлын хэсэг байгуулж уг ажлын хэсгийг ахалж ажилласан болно. Ийнхүү ажиллахдаа НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, Хүний эрхийн Хороо, Эрүүдэн шүүхийн эсрэг хороо зэргээс Монгол Улсад өгсөн зөвлөмж, тусгай илтгэгч, экспертүүдийн санал, дүгнэлт, бусад улсын хүний эрхийн үндэсний байгууллагын ижил төсөөтэй хуулийг судлах ажлыг хариуцан гүйцэтгэж, төслийн эх баригчаар ажилласан. Улмаар Хууль зүй, дотоод хэргийн яам 2018 онд ХЭҮК-ын тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулахад уг ажлын хэсэгт орж ажилласан болно. Ажлын хэсэг ХЭҮК-оос санаачлан боловсруулсан дээрх хуулийн төсөл дээр суурилан ажиллаж, төслийг боловсронгуй болгож УИХ-д өргөн барьсан.<br>Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Хуулийн төслийг 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр УИХ баталсан ба өдгөө хүчин төгөлдөр үйлчилж байна.<br>**ҮЙЛ АЖИЛЛАГАА №3**<br>Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; **Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн төсөлд Комиссын санал боловсруулах ажлын хэсэгт гишүүнээр ажиллах (ХЭҮК, 2013-2019 он)**<br>Үйл ажиллагааны гол агуулга; Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т заасан хууль тогтоомж, захиргааны байгууллагын шийдвэрийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал гаргах чиг үүргийг хэрэгжүүлэхдээ Комиссын ажлын албанаас байгуулагдсан ажлын хэсэг хуулийн төслүүдэд дүн шинжилгээ хийж ажилладаг ба 2013-2016, 2018-2020 оны хугацаанд Комисст санал авахаар ирүүлсэн төслүүдэд санал боловсруулах ажлын хэсгийн ахлагч, гишүүнээр ажиллаж холбогдох хууль тогтоомжуудад санал боловсруулж хүргүүлсэн. Тухайлбал 2019 онд 10 хууль тогтоомжийн төсөлд 58 санал, 2018 онд 27 хууль тогтоомжийн төсөлд 107 санал, 2015 онд 24, 2014 онд 25, 2013 онд 17 хууль тогтоомжийн төсөлд санал |

| | | |
|---|---|---|
| | | хүргүүлсэн байна.<br>Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Комиссоос хүргүүлсэн саналуудын багагүй хувийг хууль санаачлагч болон хууль тогтоогчид хуулийн төсөлдөө тусгаж батлуулсан байна.<br>Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; ХЭҮК-ын ажлын албаны дарга, тамгын газрын дарга нар.<br>Ажлын хэсгийн тушаалуудыг хавсаргав.<br><br>**ҮЙЛ АЖИЛЛАГАА №4**<br>Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 2 болон 3 дахь илтгэлийн дагуу хүргүүлсэн хөндлөнгийн мэдээлэл (Хүний эрхийн Үндэсний Комисс, 2018 оны 5-7 сар)**<br>Үйл ажиллагааны гол агуулга; Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заасан хүний эрхийн талаарх олон улсын гэрээнд нэгдэн орох, соёрхон батлах эсэх талаар санал хүргүүлэх, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөл болон гэрээний хороодод мэдээлэл хүргүүлэх чиг үүргийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн дагуу хүргүүлэх хөндлөнгийн мэдээллийг бэлтгэх ажлыг гүйцэтгэж, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороонд хүргүүлсэн. Тус хөндлөнгийн мэдээллийг бэлтгэхдээ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Иргэний хуулийн холбогдох зохицуулалтад дүн шинжилгээ хийж, нэгдэн орсон гэрээний хэрэгжилтийн тайлангийн хүрээнд Монгол Улсын төрөөс анхаарах ёстой асуудлыг бие даасан, хараат бус илтгэлийн хэлбэрээр боловсруулсан.<br>Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; The Written Contribution of the National Human Rights Commission of Mongolia (NHRCM) to Twentieth Session of The Committee On The Rights Of Persons with Disabilities On Mongolia’s Implementation of the Convention On the Rights of Persons With Disabilities сэдэвт хөндлөнгийн тайланг хүргүүлж, НҮБ-ын ХЭДКГ-ын удирдан хөтөлдөг гэрээний хэрэгжилтийн тайлангийн санд багтаасан ба Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооны ээлжит хурлаар хэлэлцсэн.<br>Хэвлэгдсэн эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар: НҮБ-ын ХБХЭХороонд хүргүүлсэн хөндлөнгийн тайланг хавсаргав.<br><br>https://tbinternet.ohchr.org/_layouts/15/TreatyBodyExternal/<br>countries.aspx?CountryCode=MNG&Lang=EN<br><br>**ҮЙЛ АЖИЛЛАГАА №5**<br>Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; “**Цагдан хоригдож буй** |

| | | |
|---|---|---|
| | | **сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилт” судалгаа (Цагдан хорих 461-р анги, бусад цагдан хорих ангиуд, 2015-2016 он)**<br>Үйл ажиллагааны гол агуулга; Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй...”, Тавин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хуульзүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ” гэж, мөн 1990 онд НҮБ-ын “Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмууд”, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1988 оны 43/173 дугаар тогтоолоор баталсан Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц зэрэгт зааснаар өөрөө өөрийгөө хамгаалах буюу өмгөөлөгчийн туслалцаа авах эрхийг баталгаажуулсан. Эдгээр эрхийн практик дээрх хэрэгжилтийг цагдан хорих 461-р анги, Дархан-Уул, Орхон аймгууд дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албад дээр очиж, сэжигтэн, яллагдагч, шүүгчдэгчдийг хамруулан судлах цогц судалгааны ажлыг гүйцэтгэх, боловсруулах, хянан тохиолдуулах, үр дүнг танилцуулах, Хүний эрхийн Үндэсний Комиссын “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл”-д тусгах ажлыг хариуцан гүйцэтгэсэн.<br>Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Судалгааны үр дүнг Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын удирдлагуудыг байлцуулан танилцуулж, Комиссын илтгэлд тусгай бүлэг болгон оруулсан ба сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчдийн хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилтэд ахиц дэвшил гаргахад чиглэсэн санал, зөвлөмжийг Комиссын илтгэлээр өгсөн.<br>Хэвлэгдсэн эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.<br><br>Монголын хуульчдын холбоон дээр тавьсан илтгэлийн талаарх мэдээлэл: https://newspress.mn/v1/p/news/8973<br><br>Судалгааны линк: https://lib4u.net/opac.php/ebook/?id=160&lib=nhrc<br><br>**ҮЙЛ АЖИЛЛАГАА №6**<br>Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; **Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх элчин сайд төсөл – Torture Prevention Ambassador Project (Эрүү шүүлтээс урьдилан сэргийлэх нийгэмлэг, Ази, номхон далайн хүний эрхийн үндэсний байгууллагуудын чуулган, 2014-2016 он)**<br>Үйл ажиллагааны гол агуулга; Швейцарийн холбооны улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг, Ази, номхон далайн бүсийн хүний эрхийн |

| | | |
|---|---|---|
| | | үндэсний байгууллагуудын чуулганаас хүний эрхийн үндэсний байгууллагуудын дунд “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх элчин сайд” төслийг санаачилж, уг төсөлд 22 улсын хүний эрхийн үндэсний байгууллагын ажилтнууд өрсөлдөж, Австрали, Зүүн Тимор, Монгол, БНСУ, Мальдив, Шинэ Зеланд, Филиппин улсын хүний эрхийн үндэсний байгууллагын төлөөлөл 9 хүн (Монгол, Мальдиваас тус бүр 2)-ийг шалгаруулсан ба эдгээр 9 элчин сайд бие даасан төслөө 3 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн болно. Миний бие өөрийн бие даасан төслийн хүрээнд Монгол Улсад Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколын дагуу байгуулахад дэмжлэг үзүүлэх, хорих байгууллагуудад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх мониторинг хийх гарын авлага боловсруулах, сонгон авсан хорих ангиудад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар олон улсын хэм хэмжээг таниулан сурталчлах сургалт, мониторингийн ажлыг хийсэн. НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколын дагуу 90 улсад Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд энэ Нэмэлт Протоколд Монгол Улс 2014 онд нэгдэн орсноос хойш эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүсийн байгаа газарт тогтмол очиж үзлэг хийх механимзыг бий болгох үүрэг хүлээсэн. Энэ үзлэгийг хэрхэн хийх талаар олон улсын байгууллагуудын туршлага, бусад хэвлүүлсэн зааварчилгаа, албан ёсны тайлбар зэргийг үндэслэн гарын авлага боловруулсан ба уг гарын авлагын дагуу Дархан-Уул, Орхон, Говь-Алтай аймаг дахь хорих анги, цагдан хорих ангиудыг сонгон авч туршилтын мониторинг хийсэн.<br>Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Үйл ажиллагааны үр дүнд цагдан хорих анги, хорих анги, эрх чөлөөг хязгаарлаж болох бусад обьектуудад урьдчилан сэргийлэх асуудлаар мониторинг хийх гарын авлагыг хэвлүүлсэн. Уг гарын авлагыг Ази, Номхон далайн бүсийн бусад хүний эрхийн үндэсний байгууллагуудын хэрэгцээнд зориулан англи, орос хэлнээ орчуулж хэвлүүлсэн. Төслийн хүрээнд сонгон авсан хорих ангиудад мониторинг хийж, нийт 95 албан хаагчийг сургалтад хамруулсан. Уг төсөл бусад элчин сайдуудын төслүүдээс шилдгээр шалгарч Бельги Улсад Европын холбооны төслийн багийнханд үр дүнг биечлэн танилцуулсан ба 2015 онд болсон Ази, Номхон далайн бүсийн хүний эрхийн Үндэсний байгууллагуудын чуулганы хуралдаанд илтгэлээ хэлэлцүүлсэн болно.<br>Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; Марко Мона (Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нийгэмлэг, Женев хот. Цахим шуудан: mona@langstrasse4.ch), Кэйт Турнер Манн (Ази, Номхон далайн бүсийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын чуулганы зохицуулагч, Сидней хот, цахим шуудан: kateturner-mann@asiapacificforum.net)<br>Хэвлэгдсэн эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар:<br>Төслийн танилцуулга: https://apt.ch/en/torture-prevention-ambassadors/<br>Мониторинг хийсэн тухай хэвлэлийн мэдээ: |

| | | |
|---|---|---|
| | | https://tortureprevention.ch/fr/blog/monitoring-visits-revealed-successive-transfers-of-detainees-in-mongolia/<br>Үр дүнгийн тайлан: https://www.apt.ch/content/files_res/tpa_good_practices_report.pdf<br><br>Хэвлэмэл тайлан болон боловсруулсан гарын авлагыг хавсаргав.<br><br>**ҮЙЛ АЖИЛЛАГАА №7-1**<br>Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; “**Монгол Улс дахь заавал хаах цэргийн алба ба хугацаат цэргийн хөдөлмөр” бодлого, практикийн дүн шинжилгээ (Олон улсын хөдөлмөрийн байгууллага, ХЭҮК, ЗХЖШ, Баян-Өлгий, Баянхонгор, Сүхбаатар аймгууд дахь харьяа анги, нэгтгэлүүд. 2013 он)**<br>Үйл ажиллагааны гол агуулга; Олон улсын хөдөлмөрийн байгууллагын дэмжлэгтэйгээр Зэвсэгт хүчний жанжин штабын харьяа барилга, инженерийн ангиудад хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулж, Сүхбаатар, Баянхонгор, Баян-Өлгий аймаг дахь барилга-инженерийн цэргийн ангиудын үйл ажиллагаа нь Монгол Улсын нэгдэн орсон Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенц, Албадан хөдөлмөрийг хориглох тухай 105 дугаар конвенц, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактуудад заасан хүний эрхийн баталгаатай хэрхэн нийцэж буйд хууль тогтоомж, бодлого, практикийн дүн шинжилгээ хийсэн.<br>Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Үр дүнг Зэвсэгт хүчний жанжин штабын удирдлагуудад танилцуулж, цаашид Зэвсэгт хүчний тухай хууль, Батлан хамгаалах тухай хуулийн зүйл заалтыг олон улсын гэрээтэй нийцүүлэх зөвлөмж санал гаргаж, ХЭҮК-ын 2014 оны “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл”-д тусгай бүлэг болгон оруулав.<br>Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; Ж.Бямбадорж (тухайн үеийн ХЭҮК-ын дарга, 99112099)<br>Хэвлэгдсэн эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.<br>Англи хэл дээр: https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_497515.pdf<br>Монгол хэл дээр: https://lib4u.net/opac.php/ebook/?id=143&lib=nhrc<br><br>Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас 2016 онд хэвлүүлсэн ба товчлон хэвлэсэн тайланг хавсаргав.<br><br>**ҮЙЛ АЖИЛЛАГАА №7-2**<br>Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; “**Монгол Улс дахь ялтны хөдөлмөр эрхлэлтийн байдал” практик судалгаа (2013 он)**<br>Үйл ажиллагааны гол агуулга; Олон улсын хөдөлмөрийн байгууллагын |

| | | |
|---|---|---|
| | | дэмжлэгтэйгээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 407, 417, 421 дүгээр хорих ангиудад практик судалгаа хийх ажлыг зохион байгуулж, хорих ангиудын үйл ажиллагаа нь Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенц, Албадан хөдөлмөрийг хориглох тухай 105 дугаар конвенц, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактуудад заасан хүний эрхийн баталгаатай хэрхэн нийцэж буйд дүн шинжилгээ хийсэн.<br>Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Үр дүнг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын удирдлагуудыг байлцуулан танилцуулж, цаашид ялтны хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлаар олон улсын гэрээнд заасан шаардлагыг сахиулж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг тавьсан ба хуульд зохих өөрчлөлтийг хийсэн болно.<br>Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; Ж.Бямбадорж (тухайн үеийн ХЭҮК-ын дарга, 99112099)<br>Хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан тавaас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл; П.Болормаа (НҮБ-ын Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газрын зохицуулагч, утас: 88002266), Тим дэ Мейер (НҮБ-ын Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Ази, Номхон далайн бүсийг хариуцсан захирал, имэйл: demeyer@ilo.org), Маря Паавлайнен (НҮБ-ын Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Ази, Номхон далайн бүсийн шинжээч, имэйл: paavilainen@ilo.org)<br>Хэвлэгдсэн эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.<br>Англи хэл дээр https://www.ilo.org/beijing/what-we-do/publications/WCMS_497510/lang--en/index.htm<br>Монгол хэл дээр https://lib4u.net/opac.php/ebook/?id=145&lib=nhrc<br><br>Практик судалгааны товч үр дүнг 2016 онд Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас хэвлүүлснийг хавсаргав.<br><br>**ҮЙЛ АЖИЛЛАГАА №8**<br>Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; **ХЭҮК-ын гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа, хяналт шалгалт зохион байгуулахад оролцох (ХЭҮК. 2012-2013 он)**<br>Үйл ажиллагааны гол агуулга; Гомдол, хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн референт болон Хэлтсийн даргын хувиар ХЭҮК-ын гишүүдэд шийдвэрлүүлэхээр хуваарилагдсан гомдол, мэдээллийг шалгах ажиллагааг зохион байгуулах, тухайлбал гомдлыг шалгаж, шийдвэрлэхтэй холбоотойгоор Комиссын гишүүний гаргаж буй шаардлага, зөвлөмжийн төсөл боловсруулах, шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах, эвлэрүүлэх, иргэдэд хүний эрхийн асуудлаар хууль зүй зөвлөгөө өгөх үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдаж ажиллав. Хэлтсийн даргын хувиар ХЭҮК-ийн гомдол шийдвэрлэлтийн |

| | | |
|---|---|---|
| | | бүртгэлийг цахим хэлбэрт шилжүүлэх санаачлага гаргаж хэрэгжүүлснээр гомдлын лавлагаа мэдээллийг цаг алдалгүй гаргахад дэвшил гарсан гэж үздэг. Дээрх хугацаанд гомдол, мэдээллийн дагуу зохион байгуулсан хяналт шалгалтууд, тухайлбал, 2012 онд “Уул уурхай ба хүний эрх” хяналт шалгалт, 2012 оны УИХ-ын сонгуульд сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтэд хийх мониторинг, хорих 407, 427-р ангид хийсэн хяналт шалгалт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тусгай сургуулиудад хийсэн хяналт шалгалтуудын төлөвлөгөөг, удирдамжийг боловсруулах, хяналт шалгалтыг зохион байгуулахад оролцсон.<br>Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Хүний эрхийн үндэсний байгууллагын нэг чухал бүрэн эрх болох гомдол шийдвэрлэх ажиллагааг хуульд заасны дагуу хуулийн хугацаанд шуурхай, үр дүнтэй зохион байгуулахад анхаарч ажилласан. Хяналт шалгалтуудаар тогтоогдсон нөхцөл байдлыг үнэлж Комиссын гишүүнээр шийдвэр гаргуулж ажилласан.<br>**ҮЙЛ АЖИЛЛАГАА №9**<br>Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; **Эрх зүйн философи гарын авлага боловсруулах ажил (2012-2013. МУИС)**<br>Үйл ажиллагааны гол агуулга; Хууль зүйн яамнаас хэрэгжүүлсэн Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн гарын авлагыг боловсруулахад зөвлөх Х.Сэлэнгэ (Хууль зүйн доктор, Ph.D, профессор), багийн гишүүн Л.Банзрагч (МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, LL.M) нартай хамтран ажилласан ба уг гарын авлагын XVI-XIX бүлгийг хариуцан боловсруулсан. Энэ хүрээнд нийтлэг эрх зүйн философи үндэс, эрүүгийн эрх зүйн философи үндэс, хувийн эрх зүйн философи үндэс, өмчлөх эрхийн философи үндсийн талаар гадаад, дотоодын эрх зүйн онолын эх сурвалжуудаас судалгаа хийж ажилласан болно.<br>Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Уг гарын авлагыг хууль зүйн их, дээд сургуулиудын бакалавр, магистрын сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна.<br>Хэвлэгдсэн эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. (http://nli.gov.mn/gariinavlaga/Erkh_Zuin_Philpsophy.pdf)<br><br>Хэвлэгдсэн хувийг хавсаргав.<br><br>**ҮЙЛ АЖИЛЛАГАА №10**<br>Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; **Үндсэн хуулийн цэцийн гишүүдэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх болон маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулах ажил (Үндсэн хуулийн цэц, 2009-2012 он)**<br>Үйл ажиллагааны гол агуулга; Нэг. Үндсэн хуулийн цэцийн гишүүдэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд: 2009-2012 онд Үндсэн хуулийн |

| | | |
|---|---|---|
| | | цэцийн Тамгын газарт шинжээчээр ажиллах хугацаанд Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нийцүүлэн иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шалгаж маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх асуудлаар Цэцийн гишүүний тогтоолын төсөл, Цэцийн бага, дунд, их суудлын хуралдааны дүгнэлт, тогтоолын төсөл боловсруулах, Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа хийх, дүгнэлт гаргах, холбогдох бусад байгууллагуудаас мэдээлэл гаргуулах ажлыг гүйцэтгэж, Цэцийн гишүүн П.Очирбат, Б.Наранчимэг нарын туслахаар ажилласан.<br>Хоёр. Маргаан хянан шийдвэрлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд: Цэцийн хуралдааны нарийн бичгийн даргын үүргийг хариуцан гүйцэтгэж, Цэцийн бага, дунд, их суудлын хуралдааны товыг гаргах, оролцогч талуудад мэдээлэх, Цэцийн хуралдаанауудад хуралдааны нарийн бичгийн даргаар ажиллаж, Цэцийн гишүүдийн зөвлөлдөх тасалгааны тэмдэглэлийг хөтлөх, нууцыг хадгалах, шийдвэрийн төслийг хянах зэрэг ажлуудыг хариуцан гүйцэтгэсэн ба 11 удаагийн дунд, их суудлын хуралдааны нарийн бичгийн даргаар ажилласан.<br>Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Үндсэн хуулийн цэцийн гишүүний тогтоол, Цэцийн шийдвэрийн төслийг боловсруулж ажилласан ба Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаарх цэцийн шийдвэрээр албажиж гарсан. Цэцийн хуралдааны нарийн бичгийн даргаар оролцсон шийдвэрүүдийн линкийг ишлэл хэсэгт хавсаргав.<br>Хэвлэгдсэн эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар:<br>Монгол Улсын Их хурлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт №06 (2009/11/18. https://www.legalinfo.mn/law/details/1052?lawid=1052)<br>Ашигт малтмалын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт №07 (2009/11/25. https://www.legalinfo.mn/law/details/976?lawid=976)<br>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай тогтоол №01 (2010/01/22 https://www.legalinfo.mn/law/details/1039?lawid=1039)<br>Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт №01 (2010/03/24 https://www.legalinfo.mn/law/details/983?lawid=983)<br>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт №02 (2010/04/02 https://www.legalinfo.mn/law/details/1054?lawid=1054)<br>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зарим |

| | | |
|---|---|---|
| | | заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэлсэн шийдвэрлэсэн тухай тогтоол №02 (2010/06/09 https://www.legalinfo.mn/law/details/1055?lawid=1055)<br>Засгийн газрын 2009 оны 86 дугаар тогтоолын заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт №04 (2010/07/07 https://www.legalinfo.mn/law/details/992?lawid=992)<br>Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйл Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт №05 (2010/10/27 https://www.legalinfo.mn/law/details/1067?lawid=1067)<br>Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг болон 40.1.1, 40.1.2 дах заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт №06 (2010/11/10 https://www.legalinfo.mn/law/details/982?lawid=982)<br>Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт №07 (2010/11/17 https://www.legalinfo.mn/law/details/1042?lawid=1042)<br>Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.3, 17.4 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай дүгнэлт №08 (2010/11/24 https://www.legalinfo.mn/law/details/1122?lawid=1122) |
| **10** | **Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр эрхэлсэн ажил**<br>Хүсэлт гаргагч хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр сүүлийн таваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:<br>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;<br>-ажлын байрны тодорхойлолт;<br>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;<br>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл. | **Албан тушаалын нэр:** Хүний эрхийн боловсрол, судалгааны хэлтсийн дарга<br>**Ажлын газрын хаяг:** Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3Г-ын 11-р байр<br>**Ажилласан хугацаа:** 2013-2016, 2018-өнөөдрийг хүртэл<br>**Ажлын байрны тодорхойлолт:** Хүний эрхийн боловсролыг дэмжих, түгээх, хууль тогтоомж, захиргааны байгууллагын шийдвэрийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал гаргах, хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбогдсон хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай санал уламжлах чиг үүргийн хүрээнд нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг Тамгын газрын даргын өмнө хариуцах.<br>**Албан тушаалын нэр:** Гомдол, хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга<br>**Ажлын газрын хаяг:** Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3Г-ын 11-р байр<br>**Ажилласан хугацаа:** 2012-2013<br>**Ажлын байрны тодорхойлолт:** Комиссын гишүүдийг гомдол, мэдээлэл хянан шийдвэрлэх, хяналт шалгалт хийх хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийн хүрээнд |

| | | |
|---|---|---|
| | | нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, гүйцэтгэлийн үр дүнг Тамгын газрын даргын өмнө хариуцах.<br>**Албан тушаалын нэр:** Бодлогын дүн шинжилгээ хариуцсан референт<br>**Ажлын газрын хаяг:** Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, ЗГ-ын 11-р байр<br>**Ажилласан хугацаа:** 2012/01-2012/09<br>**Ажлын байрны тодорхойлолт:** Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн төсөл боловсруулах, Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн төсөл хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцэж буй эсэхд дүн шинжилгээ хийж, Комиссын гишүүний саналын төсөл боловсруулах, хүний эрхийн асуудлаарх судалгааны ажлыг төлөвлөх, зохион байгуулах ажлыг Хэлтсийн даргын өмнө хариуцах. |
| 11 | **Хүний эрхийг хүндэлж, дээдэлдэг байдал**<br>Хүсэлт гаргагчийн хүний эрхийн мэдлэг, чадвар, хүний эрхийг хүндэтгэж, дээдэлдэг гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 үйл ажиллагааг сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:<br>-үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;<br>-үйл ажиллагааны гол агуулга;<br>-үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;<br>-үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;<br>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан тавааc доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл;<br>-хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. | <br>**ҮЙЛ АЖИЛЛАГАА №1**<br>Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; **Хүний эрхийн Үндэсний Комиссын жил тутмын “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл” боловсруулах ажил (ХЭҮК. 2020, 2019, 2018, 2015, 2014, 2013 он)**<br>Үйл ажиллагааны гол агуулга; Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасны дагуу ХЭҮК нь жил тутам “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл”-ийг боловсруулж УИХ-д өргөн барьдаг. Энэхүү баримт бичиг нь тухайн жилд Монгол Улсад хүний эрхийн нөхцөл байдал ямар байсныг илтгэх, төрөөс хүний эрх, эрх чөлөөний баталгааг бүрдүүлэхэд юуг анхаарах ёстойг илэрхийлдэг бодлогын түвшний баримт бичиг юм. Комисст ажилласан хугацаанд уг илтгэлийг боловсруулахад тодорхой сэдвүүдийг хариуцан ахалж, Комиссын гишүүний өгсөн чиглэлийн дагуу илтгэлийн бүлгийг хууль зүйн болон хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ хийх, мэдээлэл цуглуулах, харьцуулах зэргээр боловсруулах, хянан тохиолдуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь илтгэлийн “Уул уурхай ба хүний эрх” 1-р бүлэг, 13 дахь илтгэлийн “Албадан хөдөлмөрийн нөхцөл байдал” 1.2-р дэд бүлэг, 14 дэх илтгэлийн “Хүний эрхийн боловсрол” 3 дугаар бүлэг, 15 дахь илтгэлийн “Цагдан хоригдож буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилт” 2 дугаар бүлэг, 18 дахь илтгэлийн “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудал” 2 дугаар бүлэг, 19 дэх илтгэлийн “Малчин эмэгтэйчүүдийн эрхийн хэрэгжилт” 1 дүгээр бүлгийг тус тус хариуцан боловсруулах багийг ахалж ажилласан.<br>www.nhrcm.gov.mn/мэдээ/илтгэл/<br><br>**ҮЙЛ АЖИЛЛАГАА №2** |

| | | |
|---|---|---|
| | | Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; “**Малчин эмэгтэйчүүдийн хүний эрхийн хэрэгжилт” судалгаа (Сонгон авсан 6 аймаг, ХЭҮК, 2019 оны 4-11 сар)**<br>Үйл ажиллагааны гол агуулга; Хүний эрхийн Үндэсний Комисст ирж буй гомдол, мэдээлэл, аймаг, сумдын төрийн захиргааны байгууллагаас гаргуулж авсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзэхэд алслагдсан аймаг, сумд дахь малчин эмэгтэйчүүд эрүүл мэндээ хамгаалуулах, хүчирхийллээс ангид байх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, эдийн засгийн зэрэг эрх, эрх чөлөөгөө баталгаатай эдэлж чадахгүй байгаа тул малчин эмэгтэйчүүдийн хүний эрхийн нөхцөл байдалд шийдвэр гаргагчдын анхаарлыг хандуулах зорилгоор 2019 онд НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр алслагдсан аймаг, сум дахь малчин эмэгтэйчүүдийн хүчирхийллээс ангид байх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн хэрэгжилтийг 6 аймгийн 18 суманд газар дээр нь очиж судлах, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулахад төлөвлөлт, удирдлагаар хангаж ажилласан ба мөн дээрх 6 аймгийн 18 сумдад очиж судалгааг хийх, тайланг хамтран боловсруулах ажлыг гүйцэтгэсэн.<br>Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Судалгаагаар малчин эмэгтэйчүүдэд тулгарч буй хүний эрхийн асуудлыг 3 бүлэгт хуваан тодорхойлж, үр дүнг холбогдох төрийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдөр танилцуулсан ба мөн үр дүнг ХЭҮК-ын “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэл”-ийн нэгдүгээр бүлэгт тусгайлан оруулж, УИХ-аар шийдвэр гаргуулахаар 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр өргөн барьсан.<br>Хэвлэгдсэн эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.<br>http://nhrcm.gov.mn/мэдээ/малчин-эмэгтэйчүүдийн-хүний-эрхийн-хэрэгжилт-хүчирхийллээс-ангид-байх-эрх-бэлгийн-болон-нөхөн-үржихүйн-эрх-эрүүл-мэнд-судалгааг-танилцууллаа/<br><br>**ҮЙЛ АЖИЛЛАГАА №3**<br>Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; **“Жендэр ба хүний эрх” бүсчилсэн сургалтыг төлөвлөх, зохион байгуулах, сургагч багшаар ажиллах (21 аймаг. 2019, 2018 он)**<br>Үйл ажиллагааны гол агуулга; Төрийн албаны зөвлөл дээр 2018-2020 онд хэрэгжиж буй “Монгол Улсад мэргэжлийн иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн 3 дахь үр дүнгийн ажил болох төрийн албанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилтын хүрээнд 2018 онд 21 аймгийн төрийн захиргааны байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтнуудыг “Жендэр ба хүний эрх” сургалтаар сургагч багшаар бэлтгэх ажлыг зохион байгуулах ажлыг гүйцэтгэсэн. Мөн энэхүү сургалтын “Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал”, “Жендэрийн асуудлаарх олон улсын эрх зүйн зохицуулалт”, “Жендэрийн мэдрэмжтэй төрийн байгууллага” сэдвүүдийг |

| | | |
|---|---|---|
| | | хариуцан зааж сургагч багшаар ажиллаж, нийт 380 гаруй төрийн албан хаагчийг сургагч багшаар бэлтгэсэн. Энэхүү сургалтыг 2019 онд үргэлжлүүлж 4-12 дугаар сард Өвөрхангай, Говь-Алтай, Баянхонгор, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Өмнөговь, Дундговь, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Завхан, Архангай, Төв, Хөвсгөл, Булган зэрэг нийт 16 аймагт зохион байгуулахдаа аймгийн төрийн захиргааны байгууллагын 718 удирдах ажилтныг хамруулахад мөн төлөвлөлт, зохион байгуулалтын асуудлыг хариуцан гүйцэтгэсэн.<br>Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Аймгуудын төрийн захиргааны байгууллагын хүний нөөцийн асуудал эрхэлсэн ажилтан, тухайн байгууллагуудын дарга нарыг чадавхижуулах сургалтыг зохион байгуулснаар төрийн албан хаагчдын жендэр ба хүний эрхийн мэдлэг нэмэгдэж, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг улс орон даяар үр дүнтэй хэрэгжүүлэхэд ахиц дэвшил, хандлагын өөрчлөлт гарсан.<br>Хэвлэгдсэн эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.<br>http://nhrcm.gov.mn/мэдээ/хөвсгөл-булган-аймагт-ажиллаж-жендэрийн-эрх-тэгш-байдлыг-хангах-тухай-хуулийн-хэрэгжилтийг-шалгаж-сургалт-явууллаа/<br><br>http://nhrcm.gov.mn/мэдээ/жендэр-ба-хүний-эрх-сургалт-хяналт-шалгалтыг-20-дахь-аймагт-явуулж-байна/<br><br>**ҮЙЛ АЖИЛЛАГАА №4**<br>Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; **Хүний эрхийн нээлттэй өдөр арга хэмжээг зохион байгуулах, оролцох ажил (Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Ховд, Баян-Өлгий, Дундговь, Баянхонгор, Өвөрхангай аймгууд. 2019, 2018, 2015, 2014, 2013, 2012 он)**<br>Үйл ажиллагааны гол агуулга; ХЭҮК 2001 онд байгуулагдсан цагаасаа хойш орон нутгийн иргэдэд өөрийн үйл ажиллагааг хүргэх зорилгоор “Хүний эрхийн нээлттэй өдөр” арга хэмжээг жил тутам явуулах болсон бөгөөд уг цогц арга хэмжээгээр хүний эрхийн хяналт шалгалт, хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаа, хууль зүйн зөвлөгөө, иргэд, олон нийт, төрийн албан хаагчид, иргэний нийгмийн байгууллагатай уулзалт хийх ажлуудыг зохион байгуулж хэвшсэн. Энэ арга хэмжээг 2019 онд Дундговь, Баянхонгор, Өвөрхангай аймгуудад, 2018 онд Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Ховд, Баян-Өлгий аймгуудад зохион байгуулахад оролцсон. Мөн 2015, 2014, 2013, 2012 онуудын дээрх арга хэмжээнд оролцсон. Уг арга хэмжээний бэлтгэл ажил, сургалтын үйл ажиллагаа, иргэд, олон нийттэй хийх уулзалт, телевизийн ярилцлага өгөх зэрэг ажлуудыг зохион байгуулж, “Халдашгүй чөлөөтэй байх эрх, эрүү шүүлтээс ангид байх эрх”, “Хүний эрхийн олон улсын механизм”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, түүний онцлог зохицуулалт” сэдэвт сургалтуудыг аймгуудын төрийн албан хаагчдад бие даан хийсэн. Аймгийн хэмжээнд дагаж мөрдөхөөр хэм хэмжээ тогтоосон актуудад хүний эрхийн зарчмын үүднээс дүн шинжилгээ |

| | | |
|---|---|---|
| | | хийхэд оролцсон.<br>Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Хүний эрхийн нээлттэй өдөр арга хэмжээний үр дүнг аймгуудын удирдлагуудыг байлцуулан дүгнэж, цаашид авах арга хэмжээний талаар Комиссын гишүүний зөвлөмж хүргүүлж, аймгийн удирдлага зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээгээ тухай бүр танилцуулж ажилласан.<br>Хэвлэгдсэн эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар:<br>Өвөрхангай http://nhrcm.gov.mn/мэдээ/хүний-эрхийн-нээлттэй-өдөр-өвөрхангай-аймагт-эхэллээ/<br><br>Баянхонгор http://nhrcm.gov.mn/мэдээ/монгол-улсын-хүний-эрхийн-үндэсний-комиссын-дарга-баянхонгор-аймагт-ажиллаж-байна/<br><br>Дундговь http://nhrcm.gov.mn/мэдээ/дундговь-аймагт-хүний-эрхийн-нээлттэй-өдөр-арга-хэмжээг-зохион-байгуулж-байна/<br><br>**ҮЙЛ АЖИЛЛАГАА №5**<br>Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; “**Хүний эрхийн соёлыг бэхжүүлэх нь” симпозиумыг хамтран зохион байгуулах, илтгэгчээр ажиллах (Гадаад харилцааны яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Хүний эрхийн Үндэсний Комисс, МУИС, Монголын хуульчдын холбоо, Монголын Эмнести интернэшнл байгууллагаас хамтран зохион байгуулсан. 2018/12/07 он)**<br>Үйл ажиллагааны гол агуулга; Монгол Улсад албан болон албан бус боловсролын тогтолцоогоор хүний эрхийн боловсролыг тодорхой хэмжээгээр олгож байгаа ч өдөр тутмын үйл хэрэг болж иргэд, хүүхэд залуус хүний эрхийн соёл, хандлагатай болж төлөвшихөд ахиц дэвшил бага гарч байгаа тул бүх талуудын оролцоотойгоор нийгэмд хүний эрхийн соёлыг бэхжүүлэх зорилгоор энэхүү симпозиумыг зохион байгуулсан ба ХЭҮК-ын талаас хамтран зохион байгуулалтыг хариуцахаас гадна хурлын “Хүний эрхийн боловсролыг үнэлэх шалгуур үзүүлэлт” хэсэгт модератораар ажиллаж, илтгэл танилцуулсан.<br>Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Тус хуралд оролцогчдоос гаргасан санал, санаачилгыг зохион байгуулагч байгууллага бүр өөрсдийн үйл ажиллагаанд тусгаж хэрэгжүүлэхээр болсон бөгөөд хүний эрхийн боловсролыг түгээх талаарх зөвлөмжийг гарган хэрэгжүүлж ажиллаж байна.<br>Хэвлэгдсэн эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.<br>http://www.mfa.gov.mn/?p=49161<br>https://www.mglbar.mn/news/3028<br>https://amnesty.mn/index.php/activity-info/98-get-involved/2018-11-05-06-50-16/112-2b-1 |

| | | |
|---|---|---|
| | | **ҮЙЛ АЖИЛЛАГАА №6**<br>Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; **Австрали Улсад Хүний эрхийн эрх зүй ба бодлогын магистрын хөтөлбөрт суралцах. (Австрали Улс, Сидней хот. 2016-2018 он)**<br>Үйл ажиллагааны гол агуулга; Австрали Улсын Засгийн газраас зарладаг Australia Awards тэтгэлэгт хөтөлбөрт 2016 онд шалгарсан ба цаашд хүний эрхийн салбарт үр бүтээлтэй, шинийг санаачилж ажиллах үүднээс Нью Саут Уэллсийн их сургуулийн Хуулийн сургуульд Хүний эрхийн эрх зүй ба бодлогын магистрын хөтөлбөрийг (Master of Human Rights Law and Policy) сонгон суралцаж, хүний эрхийн мэдлэг, чадвараа нэмэгдүүлж, зарим тодорхой эрхийн чиглэлээр мэргэшсэн. Магистрын хөтөлбөрт суралцахдаа хүний эрхийн олон улсын эрх зүй, хөгжлийн бэрхшээлттэй хүмүүсийн эрх, хүүхдийн эрх, уугуул хүмүүсийн эрх, НҮБ болон олон улсын байгууллагуудын эрх зүйн чиглэлээр мэргэшин судалж, сүүлийн үеийн онол, хандлага, үзэл баримтлалаас суралцсан.<br>Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Тус сургуулийг 2018 оны 1 дүгээр сард төгсч ирээд ХЭҮК-т ажиллахдаа хариуцсан чиг үүргийн хүрээнд хүний эрхийн боловсролыг түгээхэд анхаарч, байгууллагаас гаргасан хүний эрхийн чиглэлийн контент, хэвлэмэл бүтээгдэхүүнийг боловсруулах, байгууллагын хүсэлт захиалгаар хийх сургалтуудад “Хүний эрхийн олон улсын гэрээ”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх”, “ИБУТЭТОУП ба хүний эрх”, “Эрүү шүүлтээс ангид байх эрх” зэрэг сэдвүүдээр сургалт хийж ажилласан.<br>Хэвлэгдсэн эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.<br>http://www.australiaawardsmongolia.org/index.php/en/<br><br>**ҮЙЛ АЖИЛЛАГАА №7**<br>Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; “**Хууль зүйн их, дээд сургуулиуд дахь хүний эрхийн боловсролын төлөв байдал” судалгааны ажил (Хүний эрхийн Үндэсний Комисс, Хууль зүйн үндэсний хүрээлэн. 2014 он)**<br>Үйл ажиллагааны гол агуулга; Албан боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаанд үнэлгээ, мониторинг хийх, энэ талаар холбогдох талуудын байр суурь, ололт амжилт, хамтын ажиллагааг тодорхойлох, нэгтгэн дүгнэх, цаашид сайжруулах талаар нэгдмэл ойлголтод хүрэх зорилгоор НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих үндэсний чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд эрх зүйч бэлтгэж буй их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт “Хүний эрх” хичээл тусгагдсан эсэх, уг хичээлийн агуулга, арга зүй, үнэлгээг харьцуулан судлах ажлыг Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран гүйцэтгэж, судалгаанд эрх зүйч бэлтгэж буй 11 их, дээд сургуулиудыг хамруулсан. Уг судалгаа нь эрх зүйч бэлтгэж буй сургуулиудын хөтөлбөрт хүний эрхийн агуулга хэрхэн туссаныг анх удаа өргөн |

| | | |
|---|---|---|
| | | хэмжээнд судалсан судалгааны ажил байв.<br>Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Судалгааны үр дүнг их, дээд сургуулиуд, БСШУЯ, Нийслэлийн боловсролын газрын удирдлагуудыг байлцуулан танилцуулж, бодлогын арга хэмжээ авах саналыг боловсруулж, УИХ-д хүргүүлсэн. Уг судалгаа нь их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт хүний эрхийн үүднээс үнэлгээ хийсэн анхны томоохон судалгаа болсон ба ХЭҮК-ын “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэл”-ийн Гуравдугаар бүлэгт тусгайлан оруулж, УИХ-аас шийдвэр гаргуулсан.<br>Хэвлэгдсэн эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.<br>http://www.nhrcm.gov.mn/media/documents/1431398094_2014-huul-zyn-bolovsrol-olgozh-buy-ih-d.pdf<br>https://lib4u.net/opac.php/ebook/?id=89&lib=nhrc<br><br>**ҮЙЛ АЖИЛЛАГАА №8**<br>Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; **Хорих байгууллагуудын албан хаагчдад зориулсан хүний эрхийн цуврал сургалт (Бүх хорих ангиуд болон 461-р цагдан хорих анги. 2014 он)**<br>Үйл ажиллагааны гол агуулга; Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын алба хаагчдын хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хүний эрхэд суурилсан хандлага төлөвшүүлэх, үйл ажиллагаагаа хүний эрхэд суурилсан арга зүйгээр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Каритас Чех байгууллагын хэрэгжүүлж буй “Монголын хорих байгууллагуудад хүний эрх болон ардчиллыг хөгжүүлэх, иргэний нийгмийг дэмжих төсөл”-ийн хүрээнд Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бүх төвлөрсөн 24 хорих анги болон Цагдан хорих 461-р ангийг оролцуулсан хүний эрхийн сургалтын хөтөлбөр боловсруулах, төлөвлөх, зохион байгуулахыг ажлыг гүйцэтгэсэн.<br>Хорих анги тус бүр дээр нэг өдрийн нийт 8.5 цагийн хугацаатай сургалтыг 9 сэдвийн хүрээнд явуулсан бөгөөд миний бие "Эрүү шүүлтээс ангид байх эрхийн асуудал", “Онцгой анхаарал шаардлагатай хоригдлууд”, “Хорих анги дахь албадан хөдөлмөр” сэдвийг хариуцан заасан. Уг хуваарийн дагуу нийт 161.5 цагийн сургалт зохион байгуулсан.<br>Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; 2014 оны 4-6 дугаар сарuudад зохион байгуулсан уг сургалтад шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 794 албан хаагчийг хамруулж, хүний эрхийн мэдлэг, ойлголтыг түгээсэн.<br>Хэвлэгдсэн эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар:<br>http://nhrcm.gov.mn/мэдээ/монголын-хорих-байгууллагуудад-хүний-эрх-болон-ардчиллыг-хөгжүүлэх-иргэний-нийгмийг-дэмжих-төслийн-хүрээнд-хорих-байгууллагын-ажилтнуудыг-хүний-эрхийн-сургалтад-хамрууллаа/<br><br>**ҮЙЛ АЖИЛЛАГАА №9** |

| | | |
|---|---|---|
| | | Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; “**Хүний эрхийн боловсрол” гарын авлагыг орчуулж, түгээх ажил (ХЭҮК. 2014, 2013 он)**<br>Үйл ажиллагааны гол агуулга; Ази, Номхон далайн бүсийн хүний эрхийн Үндэсний байгууллагуудын Чуулганаас эрхлэн гаргасан “Хүний эрхийн боловсрол” гарын авлагыг монгол хэлнээ орчуулах ажлыг хамтран гүйцэтгэсэн. Уг гарын авлага нь хүний эрхийн боловсролыг иргэдэд хэрхэн хүргэх талаарх аргачилсан заавар юм. Уг гарын авлагыг хэвлэмэл болон цахим хэлбэрээр түгээх ажлыг 2013-2014 онд хийсэн бөгөөд хүний эрхийн боловсрол нь хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн түгээмэл соёлыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг тул энэ төрлийн боловсролын үйл ажиллагааг түгээхдээ сургагч багш нар хэрхэн ажиллах талаар үе шаттай зааварчилгааг багтаасан.<br>Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Гарын авлагыг ХЭҮК-оос эрхлэн хэвлүүлсэн ба цахим хувилбараар Ази, Номхон далайн хүний эрхийн үндэсний байгууллагуудын чуулганы вэб сайт болон ХЭҮК-ын цахим номын сангаар нийтийн хүртээл болгож байна.<br>Хэвлэгдсэн эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар:<br>https://www.asiapacificforum.net/resources/human-rights-education-manual/<br>https://lib4u.net/opac.php/ebook/?id=23&lib=nhrc<br>Хэвлэгдсэн хувийг хавсаргав.<br><br>**ҮЙЛ АЖИЛЛАГАА №10**<br>Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; **“Хүний эрхийн товч тайлбар” ном боловсруулах ажил (ХЭҮК. 2012 он)**<br>Үйл ажиллагааны гол агуулга; Монгол Улсад хүний эрхийн чиглэлийн нэр томьёог тодорхойлсон, онолын үүднээс ойлголт өгөхүйц ном, гарын авлага байхгүй тул иргэд, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор уг товч тайлбарыг боловсруулж хэвлүүлсэн. Товч тайлбарыг боловсруулахад салбарын бусад мэргэжилтнүүдийн хамт зохиогчоор ажиллаж, номыг редакторлаж хэвлүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэсэн. Ингэхдээ хүний эрхийн нэр томьёог орчуулах, илэрхийлэхэд шаардлагатай мэргэжлийн ном зохиолууд, судалгаа, шинжилгээний материалуудыг монгол болон англи хэл дээр судалсан.<br>Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Уг ном Виктор Кондэгийн гаргасан хүний эрхийн нэр томьёоны тайлбар тольтой нэгэн адил эрэлттэй бүтээл болсон ба 2012 оноос хойш 4 удаа шинэчлэгдэн хэвлэгдсэн. Хувийг хавсаргав.<br>Хэвлэгдсэн эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.<br>http://nhrcm.gov.mn/мэдээ/хүний-эрхийн-товч-тайлбар-ыг-монгол-улсад-анх-удаа-гаргалаа/<br>Хэвлэгдсэн хувийг хавсаргав. |

| | | |
|---|---|---|
| 12 | **Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршлагын талаар**<br>Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний албан тушаалд нэр дэвших тухай хүсэлт гаргагч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгчээр ажиллаж байсан бол тэдгээрийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:<br>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;<br>-ажлын байрны тодорхойлолт;<br>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;<br>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан тавaас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл<br>**Жич: Энэ зүйл нь Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргагчид хамаарахгүй.** | |
| 13 | **Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар**<br>Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн эсхүл хүний эрхийн бусад холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ.<br>-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана.<br>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаалын нэр, огноог бичнэ. | Монголын хуульчдын холбоо<br><br>Гэрчилгээний дугаар: 1519<br><br>Гишүүн болсон огноо: 2014/07/07<br><br>Гишүүнчлэлийг түдгэлзүүлсэн: Төрийн албан хаагчийн хувиар гишүүнчлэлийг түдгэлзүүлж, багц цагаа хангаж байна. |
| 14 | **Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл**<br>-Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.<br>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.<br>-лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, яриа, огноо | **ӨӨРИЙН БОЛОВСРУУЛСАН, ХЯНАСАН НОМ:**<br><br>*Дэлхийн өөрчилсөн 12 ном* (Орчуулсан) Бемби сан хэвлэлийн газар. 2019 он<br>Хувийг хавсаргав.<br><br>*Хорих байгууллагад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх мониторинг хийх гарын авлага* (Зохиогч) Адмон хэвлэлийн газар. 2016 он<br>Хувийг хавсаргав.<br><br>*Хүний эрхийн боловсрол* (хамтран орчуулсан) Бемби Сан хэвлэлийн газар. 2015 он. |

| | | |
|---|---|---|
| | болон газрыг зааж, энэ талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан бол энэ тухай бичнэ. Хэрэв таны илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч агуулгыг бичнэ.<br>-хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлагуудын огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэгээс хуулбарлан өгнө.<br><br>**Жич:** Дээр дурдсан материал тус бүр хоёр хувийг хавсаргана. | Хувийг хавсаргав.<br><br>*Эрх зүйн философи* (Хамтран зохиогч) BCI хэвлэлийн газар. 2013 он.<br>Линк: http://nli.gov.mn/gariinavlaga/Erkh_Zuin_Philpsophy.pdf<br>Хувийг хавсаргав.<br><br>*Хүний эрхийн товч тайлбар* (Хамтран зохиогч) Мөнхийн үсэг хэвлэлийн газар. 2012 он. (2013, 2015 онуудад 4 удаа хэвлэгдсэн)<br>Линк: https://drive.google.com/file/d/0B36tnIplS_PfQjBxSkxEd0xFMTg/view<br>Хувийг хавсаргав.<br><br>*Хувийн өмчийн онол* (Зохиогч) Бемби сан хэвлэлийн газар. 2008 он.<br>Хувийг хавсаргав.<br><br>**ӨӨРИЙН БИЧСЭН ӨГҮҮЛЭЛ:**<br><br>*“Has the minority rights framework suffered because of the advancement of Indigenous peoples’ rights within the United Nations system?”. Хууль дээдлэх ёс. 2019/05*<br>Хувийг хавсаргав.<br><br>*“Command Responsibility is the Essential to the Enforcement of International Humanitarian Law: In the example of Bemba Case at the International Criminal Court”. Хууль дээдлэх ёс. 2018/05*<br>Хувийг хавсаргав.<br><br>*"Цаазаар авах ялыг халах тухай ИБУТЭТОУП-ын 2-р Нэмэлт Протоколоос оролцогч улс гарч болох уу?" “Хүний эрх” сэтгүүл. 2018/01, “Үндсэн хууль ба цаазын ял” эмхэтгэл (2018. Эмнести Интернэшнл)*<br>Хувийг хавсаргав.<br><br>*“Хууль тогтоомжийг олон улсын гэрээтэй нийцүүлэх замаар цэргийн албан хаагчдыг албадан хөдөлмөрөөс хамгаалах нь”. Хүний эрх сэтгүүл. 2015/02*<br>Хувийг хавсаргав.<br><br>*“Ахмад настны эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангах нь” Хүний эрх сэтгүүл. 2014/02*<br>Хувийг хавсаргав.<br><br>*“Оюуны өмчийн онолын чиг хандлага: Радикаль ба хяналтын онолууд” Хүний эрх сэтгүүл. 2014/01* |

| | | |
|---|---|---|
| | | Хувийг хавсаргав.<br><br>*“Өмчлөх эрхийн сэтгэлгээний түүхэн асуудал” Хүний эрх сэтгүүл. 2013/02*<br>Хувийг хавсаргав.<br><br>*“НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн Нэмэлт Протоколд дэлхийн улсууд нэгдэн орсон нь” Хүний эрх сэтгүүл. 2013/01*<br>Хувийг хавсаргав.<br><br>*“Эрүүл орчинд амьдрах эрх, хүний үндсэн эрх болох нь”. Хүний эрх сэтгүүл. 2012/02*<br>Хувийг хавсаргав.<br><br>**ӨӨРИЙН ХАРЬЯАЛАГДДАГ БАЙГУУЛЛАГЫН НЭРИЙН ӨМНӨӨС БЭЛДСЭН:**<br><br>*“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12-19 дэх илтгэл”-үүд* (ХЭҮК. 2020 он) Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь илтгэлийн “Уул уурхай ба хүний эрх” 1-р бүлэг, 13 дахь илтгэлийн “Албадан хөдөлмөрийн нөхцөл байдал” 1.2-р дэд бүлэг, 14 дэх илтгэлийн “Хүний эрхийн боловсрол” 3 дугаар бүлэг, 15 дахь илтгэлийн “Цагдан хоригдож буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилт” 2 дугаар бүлэг, 18 дахь илтгэлийн “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудал” 2 дугаар бүлэг, 19 дэх илтгэлийн “Малчин эмэгтэйчүүдийн эрхийн хэргэжилт” 1 дүгээр бүлгийг тус тус хариуцан боловсруулах багийг ахалж ажилласан.<br>Линк: http://nhrcm.gov.mn/мэдээ/илтгэл/<br><br>ХЭҮК-оос санал авахаар ирүүлсэн хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн төсөлд санал өгөх ажлын хэсгийн гишүүнээр 2013 оноос хойш ажиллаж, төслүүдэд санал өгсөн.<br>Ажлын хэсэг байгуулах тухай 2013/07/18-ны өдрийн 41 дүгээр тушаал, 2015/06/19-ны өдрийн 15 дугаар тушаалуудыг хавсаргав.<br><br>*“Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хохирсон хүүхдүүд, хэргийн шийдвэрлэлт”* Баримтын дүн шинжилгээ (ХЭҮК. 2020. Хянасан)<br>Монгол Улсын хэмжээнд өсвөр үеийнхний БЗДХ-ын өвчлөл, өсвөр насны охидын төрөлт, үр хөндөлт, ураг зулбалт, эх хүүхдийн эндэгдэл болон хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, нөхөн үржихүйн эрхийн эсрэг гэмт хэргийн мэдээлэл зэргийг холбогдох байгууллагуудаас гаргуулан авч, тэдгээрт дүн шинжилгээ хийсэн. Дүн шинжилгээг Улсын Ерөнхий Прокурорын газар, |

| | | |
|---|---|---|
| | | Цагдаагийн ерөнхий газраас тус тус ирүүлсэн мэдээлэлд үндэслэн хийсэн.<br><br>*“Монгол Улс дахь малчин эмэгтэйчүүдийн хүний эрхийн хэрэгжилт” судалгааны тайлан* (ХЭҮК, НҮБХАС. 2019 он. Хамтран боловсруулсан)<br>6 аймгийн 18 суманд газар дээр нь очиж судлах, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулахад төлөвлөлт, удирдлагаар хангаж ажилласан ба мөн дээрх 6 аймгийн 18 сумдад очиж судалгааг хийх, тайланг хамтран боловсруулах ажлыг гүйцэтгэсэн.<br>Линк: https://lib4u.net/opac.php/ebook/?id=168&lib=nhrc<br><br>“Хүний эрхэд суурилсан бичил уурхай” (ХЭҮК. 2018. Хянасан)<br>Линк: https://lib4u.net/opac.php/ebook/?id=85&lib=nhrc<br><br>“Гэгээн нас” комик ном (ХЭҮК. 2018 он. Хянасан)<br>Линк: https://lib4u.net/opac.php/ebook/?id=78&lib=nhrc<br><br>*“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт, сургууль завсардалт”* баримтын дүн шинжилгээ (ХЭҮК. 2018 он. Хянасан)<br>БСШУЯ-тай хамтран 21 аймгаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн цэцэрлэг, сургуульд хамрагдалтын талаарх мэдээллийг гаргуулан авч тэдгээр хүүхдүүдийн сурч боловсрох эрх хэрхэн хэрэгжиж буйд дүн шинжилгээ хийсэн. Дүн шинжилгээнд 21 аймгийн 2-18 насны 6,194 хүүхэд хамрагдсан бөгөөд тухайн хүүхдүүдийн цэцэрлэг, сургуульд хамрагдалт, хүйсийн харьцаа, насны бүлэг, сургуульд хамрагдаагүй шалтгаан, хөгжлийн бэрхшээлийн төрөл зэргийг ирүүлсэн мэдээлэлд тулгуурлан гаргасан.<br>Линк: https://lib4u.net/opac.php/ebook/?id=163&lib=nhrc<br><br>*“Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрх” судалгааны тайлан* (Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо ТББ, ХЭҮК. 2018 он. Хянасан)<br>Линк: http://nhrcm.gov.mn/мэдээ/хөгжлийн-бэрхшээлтэй-охид-эмэгтэйчүүдийн-бэлгийн-болон-нөхөн-үржихүйн-эрүүл-мэндийн-тусламж-үйлчилгээний-чанар-хүртээмжийг-сайжруулах-шаардлагатай-байна/<br><br>*“Зэвсэгт хүчин ба хүний эрх”* (Сургалтын гарын авлага. Хамтран орчуулсан. 2018 он)<br>Линк: https://lib4u.net/opac.php/ebook/?id=77&lib=nhrc<br><br>“*Цагдан хоригдож буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилт*” судалгааны тайлан (Хамтран боловсруулсан. 2016 он) |

| | | |
|---|---|---|
| | | Шүүхийн өмнөх шатанд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээр татагдан цагдан хоригдож буй хүмүүсийн өмгөөлөгч авах, өөрт холбогдох хэргийн талаар хангалттай хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилтийг судалсан.<br>Линк: https://lib4u.net/opac.php/ebook/?id=160&lib=nhrc<br><br>"Монгол Улс дахь ялтны хөдөлмөр эрхлэлтийн байдал: Практик судалгаа" (Удирдан зохион байгуулж, хамтран боловсруулсан. 2016)<br>Линк: https://lib4u.net/opac.php/ebook/?id=145&lib=nhrc<br><br>"Монгол Улс дахь заавал хаах цэргийн алба ба хугацаат цэргийн хөдөлмөр: Бодлого, практикийн дүн шинжилгээ" (Удирдан зохион байгуулж, хамтран боловсруулсан. 2016)<br>Линк: https://lib4u.net/opac.php/ebook/?id=143&lib=nhrc<br><br>*"Монгол Улс дахь хүний эрхийг хамгаалагчдын эрхийн хэрэгжилтийн төлөв байдал"* судалгааны тайлан (Хамтран боловсруулсан. 2015 он)<br>Хүний эрхийг хангах, хамгаалах механизмыг төгөлдөржүүлэхийн тулд хүний эрхийг хамгаалагчдын эрх, түүний хэрэгжилтийн төлөв байдлыг судлан тогтоож, судалгааны үндэслэл бүхий мэдээлэлд үндэслэн хүний эрхийг хамгаалагчдын эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангах санал, зөвлөмж боловсруулан шийдвэрлүүлэх зорилгоор гүйцэтгэсэн.<br>Линк: https://lib4u.net/opac.php/ebook/?id=159&lib=nhrc<br><br>*"Ахмад настны нийгмийн хамгаалал ба хүний эрхийн асуудал"* судалгааны тайлан (Хамтран боловсруулсан. 2015 он)<br>Ахмад настны эрхийн асуудлаар хийсэн судалгаа хангалтгүй байгаа зэргийг дүгнэж ерөнхий зураглалыг гаргах, ахмад настны эрхийг хамгаалж буй улс орнуудын туршлага, одоо үйлчилж байгаа Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн хэрэгжилт, ахмад настны эрхийг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг судлах зорилгоор судалгааг гүйцэтгэсэн.<br>Линк: https://lib4u.net/ebook/?lib=nhrc&id=157<br><br>*"Үйлдвэрчний эвлэлийн байгууллагад ажиллаж буй хүний эрхийг хамгаалагчийн үйл ажиллагааны баталгаа"* судалгааны тайлан (Хянасан. 2015 он)<br>Үйлдвэрчний эвлэлийн холбоо, түүний аймаг, нийслэл дэх албан болон албан бус салбарт ажиллаж буй идэвхтэн, сонгуульт ажилтан, гишүүдийн эдийн засаг, нийгэм, эрх зүйн баталгаа хэрхэн хангагдаж байгааг тодорхойлох, үйлдвэрчний эвлэлийн байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр санал, зөвлөмж гаргах зорилгоор гүйцэтгэсэн. |

| | | |
|---|---|---|
| | | Линк: https://lib4u.net/opac.php/ebook/?id=158&lib=nhrc<br><br>“*Хууль зүйн дээд сургуулиуд дахь хүний эрхийн боловсрол*” судалгааны тайлан (Хамтран боловсруулсан. 2014 он)<br>Линк: https://lib4u.net/opac.php/ebook/?id=89&lib=nhrc<br><br>"*Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын холбогдох хороодоос Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжийн эмхэтгэл*" (Хамтран эмхэтгэсэн. 2014 он)<br>Линк: https://lib4u.net/opac.php/ebook/?id=79&lib=nhrc<br><br>“*Монгол Улс дахь мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэгт ногдуулж буй ял шийтгэл, тулгамдаж буй асуудал*” судалгааны тайлан (Хамтран боловсруулсан. 2013 он)<br><br>*“Бичил уурхайн салбар дахь хүний эрх”* хүний эрхийн судалгаа, нөлөөллийн ажлын тайлан (Боловсруулсан. 2013 он)<br>Линк: https://lib4u.net/opac.php/ebook/?id=91&lib=nhrc<br><br>“Хүн амины гэмт хэрэгт ял шийтгүүлж, ШШГЕГ-ын харьяа эмэгтэйчүүдийн хорих 0407-р ангид ял эдэлж буй ялтнуудын үйлдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлд хийсэн судалгаа” (Хамтран боловсруулсан. 2012 он)<br>Линк: https://lib4u.net/opac.php/ebook/?id=92&lib=nhrc<br><br>**ЛЕКЦ, ИЛТГЭЛ, НЭЭЛТИЙН ҮГ:**<br><br>*“Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал, олон улсын эрх зүйн зохицуулалт”* (Лекц. 2020/01/07. ХЭҮК-оос Нийслэлийн төр захиргааны байгууллагын удирдах ажилтнуудад зориулсан “Жендэр ба хүний эрх” сургалт. Линк: https://www.ulaanbaatar.mn/Home/newsdetail?dataID=46457)<br><br>*“Цагдан хорих анги дахь хүний эрх: Хууль зүйн туслалцаа авах эрхийн жишээн дээр”* (Илтгэл. 2019/03/12. Монголын хуульчдын холбооны зохион байгуулсан “Хууль зүйн туслалцаа авах эрхийн баталгаа, тулгамдаж байгаа асуудлууд” сэдэвт хэлэлцүүлэг.<br>Линк: https://newspress.mn/v1/p/news/8973)<br><br>*“Хүний эрхийн боловсрол түгээж буй байдлыг хэмжих шалгуур үзүүлэлт”* (Илтгэл. 2018/12/07. Гадаад харилцааны яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, ХЭҮК, МУИС, Монголын хуульчдын холбоо, Монголын Эмнести интернэшнл байгууллагаас хамтран зохион байгуулсан “Хүний эрхийн соёлыг |

| | | |
|---|---|---|
| | | бэхжүүлэх нь" симпозиум.<br>Линк: https://www.mglbar.mn/news/3028)<br><br>*"Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг хүний эрхийн үндэсний байгууллагын дэргэд ажилуулж буй туршлага"* (Илтгэл. 2018/10/15-16. Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас НҮБ-ын Хүний эрхийн дээд Комиссарын албатай хамтран зохион байгуулсан "Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал" зөвлөлдөх уулзалт.<br>Линк: http://www.mfa.gov.mn/?p=48439)<br><br>*"Цаазаар авах ялыг халах тухай иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Нэмэлт II протоколоос оролцогч улс буцаж гарах боломжтой юу?"* (Илтгэл. 2018/09/20. Монголын Эмнести Интернэшнл байгууллагаас зохион байгуулсан "Үндсэн хууль ба цаазаар авах ял" хэлэлцүүлэг.<br>Линк: https://www.mglbar.mn/news/2901)<br><br>*"Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх элчин сайдын хэрэгжүүлэх үйл ажиллагаа"* (Илтгэл. 2015/08/27. Ази, номхон далайн хүний эрхийн үндэсний байгууллагуудын чуулганаас зохион байгуулдаг 2 жил тутмын Хүний эрхийн үндэсний байгууллагуудын чуулган болон 20 дахь хурал.<br>Линк: https://www.asiapacificforum.net/resources/presentation-tpa-mongolia-apf-20/)<br><br>*"Зарим оронд шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийн эрх зүйн болон нийгмийн баталгааг бүрдүүлсэн байдал"* (Илтгэл. 2013/05. Шийдвэр гүйцэтгэгчдийн нэгдсэн зөвлөгөөн.<br>Линк: http://www.niislel.cd.gov.mn/content/1698.shtml?sel=303)<br><br>**ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛД ӨГСӨН ЯРИЛЦЛАГА:**<br><br>*"ХЭҮК шүдтэй, шүдгүй арслангийн аль нь ч байх нь зохимжгүй"*<br>("Зууны мэдээ" сонин. 2019/12/25 №255 (6222).<br>Линк: http://gogo.mn/r/x0x9o<br>Линк: http://www.shuud.mn/a/515442<br>Хувийг хавсаргав.<br><br>*"Хүний эрхийн боловсрол түгээх ажлыг өргөн хүрээнд хэрэгжүүлэх ёстой"* ("Үндэсний шуудан" сонин. 2019/03/14 №46 (3257).<br>Линк: http://www.npost.mn/a/162806)<br>Хувийг хавсаргав.<br><br>*"Monitoring visits revealed successive transfers of detainees in Mongolia"* |

| | | |
|---|---|---|
| | | (“Association for the Prevention of Torture. 2016/01/22.<br>Линк: https://www.apt.ch/en/blog/monitoring-visits-revealed-successive-transfers-of-detainees-in-mongolia/#.VsGzUOZ8nb0)<br>Хувийг хавсаргав.<br><br>*“Ахмад настны эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангах нь хамгийн чухал асуудал”* (Vip76.mn сайт. 2014/10/31<br>Линк: https://vip76.mn/content/27770)<br>Хувийг хавсаргав.<br><br>*“Лиценз эзэмшигч нь газар эзэмшигчээс давуу эрх эдлэхгүй.”* (Vip76.mn сайт. 2013/08/22)<br>Линк: https://vip76.mn/content/19047<br><br>Нүүдэл шийдэл – “Утаа ба улс төрийн шийдэл” (Монгол HD телевиз.<br>Линк: https://www.youtube.com/watch?v=R5b4IEEiIz4)<br><br>Унаач хүүхдүүдийн эрхийн асуудлаар - Оргил цагийн зочин (Монгол HD телевиз. 2014/02/10<br>Линк: https://www.youtube.com/watch?v=uIHfUzO1Uys)<br><br>“Эрүү шүүлтийн элчин сайдын явуулах үйл ажиллагааны тухай ярилцлага” (2015/03/11 APT)<br>Линк: https://www.youtube.com/watch?v=82S3MNbrSxg) |

--- oOo ---